**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 16 өдөр Дугаар А/98 Мандалговь

Хөрөнгө гаргах тухай

Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай 2021 онд байгуулсан гэрээний 3.1.7 дугаар зүйл, мөн сайдын 2021 оны а/01 дугаар "Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай" тушаал, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 2,3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 5 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Монгол цэргийн өдөр", "Зэвсэгт хүчин үүсэн байгууллагдсаны 100 жил"-ийн ойг угтаж аймгийн төв номын сантай хамтарч мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, насанд хүрэгчдийн дунд "ЭХ ОРНЫ БАХАРХАЛ-ЭР ЦЭРЭГ" богино өгүүллэгийн уралдааныг цахимаар зохион явуулсугай.

2. Уралдааны зардлын тооцоог хавсралтаар батлагсугай.

3. Уралдаанд шаардагдах 600,000 (зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүрэг гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

481210272

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын
16.-ны өдрийн A/98..дугаар захирамжийн
хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт |
|---|---|---|---|
| 1 | МСҮТ, ЕБС-ийн 1,2,3-р байр эзлүүлнэ | 1-р байр 100,000<br>2-р байр 80,000<br>3-р байр 60,000 | 240,000 |
| 2 | Насанд хүрэгчид 1,2,3-р байр эздүүлнэ | 1-р байр 100,000<br>2-р байр 80,000<br>3-р байр 60,000 | 240,000 |
| 4 | Өргөмжлөл | 6*20.000 | 120,000 |
| **Бүгд** | | **600,000** | |